



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/122/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган аймаг 2023 он	Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Ахлах аудитор: Г.Намчинсүрэн Утас: 70342716 Цахим хаяг: Erdeneb@auditgov.mn Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

---

<b>1.ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ.....</b>	<b>1-2</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....</b>	<b>7</b>
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН .....</b>	<b>16</b>
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>18</b>
5.1 Төлбөрийн акт .....	18
5.2 Албан шаардлага .....	18
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>19</b>

## **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ



### БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 83  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ОРХОН СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ  
Т.ЭНХТУЯА ТАНАА

#### Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон сумын Эрүүл мэндийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн дараах буруу илэрхийлэл, зөрчлүүд нь санхүүгийн тайланд материаллаг бөгөөд түгээмэл тархалттай байна.Үүнд:

- Шатахууны зардлаас түүвэрлэн тулгалт хийхэд шатахуун тооцож олгохдоо автомашины зарцуулах шатахууны норм нормативыг баримтлаагүй нийт 576.1 мянган төгрөгийг илүү тооцон олгож Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 190 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.
- Хүнсний зардлаас түүвэрлэн тулгалт хийхэд хүнсний тайланд нормоор тогоочид олгосон хүнснээс нийт 1,649.4 мянган төгрөгөөр илүү дүнгээр зарлагдсан нь НББ-ийн тухай хуулийн 13.1, 13.1.7, 20.2.4 дэх заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

006020090

- Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ нийт 56,907.2 мянган төгрөгийн НӨАТ-ын баримтыг аваагүй /цахим Е баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2."бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй". заалтуудыг зөрчиж НӨАТ-ын баримтгүй эм, эмийн хэрэгсэл бэлдсэн нь санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.
- Нийт 284,992.1 мянган төгрөгийн бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн тушаалыг зөрчин ковидын урамшууллын мөнгөн дүнг өөрчлөн нийт 4,462.5 мянган төгрөгийг албан хаагчдад зөрүүтэй тооцоолон олгосон нь НББ-ийн тухай хуулийн 13.1,14.1.1, 20.1.1, 20.1.2, 20.2.4 дахь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.
- Бодогдсон цалингаас суутгах НДШ, ХХОАТ-ын суутгалыг дутуу суутган гарт олгох цалинг 1004.8 мянган төгрөгөөр илүү олгосон нь НББ-ийн тухай хуулийн 13.1,14.1.1, 20.1.1, 20.1.2, 20.2.4 дахь заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Булган аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төв нь 1 хөтөлбөр, 4 арга хэмжээний хүрээнд нийт 626,278.6 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 591,571.1 мянган төгрөгийг зарцуулж хөтөлбөр, арга хэмжээний биелэлт 94 хувьтай байна.

#### **Аудитын гол асуудал**

Булган аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төв нь Санхүүгийн тайлангийн тодруулга дахь эмийн үлдэгдэл эмийн тайлангийн эхний үлдэгдлээс 1,439.4, эцсийн үлдэгдлээс 36,654.4 мянган төгрөгөөр, санхүүгийн тайлангийн тодруулга дахь тайлант онд нэмэгдсэн эм, эмийн тайлангийн тайлант онд нэмэгдсэн эмээс 112,626,9 мянган төгрөгөөр зөрүүтэй, санхүүгийн тайлангийн тодруулга дахь тайлант онд зарцуулсан эм, эмийн тайлангийн тайлант онд зарцуулсан эмээс 77,728.2 мянган төгрөгөөр зөрүүтэй, тайлант онд нийт 109,815.8 мянган төгрөгийн

эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан боловч эмийн тайланд 67,957.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг эмийн тайланд орлогод аваагүй зэрэг зөрчлүүд нь НББ-ийн тухай хуулийн 13.1,14.1.1, 20.1.1, 20.1.2, 20.2.4 дэхь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>251,179,653.68</u></b>	<b><u>145,540,434.72</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	22,925,484.09	40,959,638.33
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	22,925,484.09	40,959,638.33
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	22,925,484.09	40,959,638.33
31211	Төрийн сангийн харилцах	17,573,494.09	40,959,638.33
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	5,351,990.00	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	127,410,615.29	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	485,286.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	126,609,000.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	316,329.29	-
3351	Байгууллагаас авах авлага	316,329.29	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	100,843,554.30	104,580,796.39
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	68,528,323.05	75,024,206.64
35110	Тусгай зориулалттай материал	7,152,379.00	328,000.00
35130	Эм боох материал	61,375,944.05	74,696,206.64
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	32,315,231.25	29,556,589.75
35410	Бичиг хэргийн материал	391,760.00	4,500.00
35420	Аж ахуйн материал	1,510,900.00	195,500.00
35440	Түлш, шатах тослох материал	3,446,000.00	1,455.01
35460	Хүнсний материал	5,554,409.25	2,801,976.44
35470	Бусад хангамжийн материал	21,412,162.00	26,553,158.30
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>184,202,586.82</u></b>	<b><u>183,213,359.21</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	184,202,586.82	183,213,359.21
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	179,892,586.82	178,903,359.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	84,049,512.02	84,049,512.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	(20,177,061.12)	(27,472,119.60)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,735,000.00	40,735,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(32,667,918.10)	(38,740,416.59)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	126,761,939.26	161,553,867.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,629,670.93)	(54,067,493.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,062,951.06	18,062,951.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,927,580.37)	(5,903,356.53)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	685,415.00	685,415.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	4,310,000.00	4,310,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.00)	(300,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,310,000.00	4,310,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>435,382,240.50</u></b>	<b><u>328,753,793.93</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>92,398.31</u></b>	<b><u>70,000.00</u></b>

41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	92,398.31	70,000.00
413	<b>Өглөг</b>	92,398.31	70,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	92,398.31	-
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	-	70,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>435,289,842.19</b>	<b>328,683,793.93</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	435,289,842.19	328,683,793.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	101,341,290.05	101,341,290.05
51101	Өмч: - төрийн	101,341,290.05	101,341,290.05
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	267,888,639.10	161,282,590.84
51210	Өмнөх үеийн үр дүн	267,888,639.10	267,888,639.10
51220	Тайлант үеийн үр дүн	-	(106,606,048.26)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	66,059,913.04	66,059,913.04
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>435,382,240.50</b>	<b>328,753,793.93</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>821,344,010.00</b>	<b>482,926,382.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>128,609,000.00</b>	-
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	128,609,000.00	-
120002	Хүүгийн орлого	126,609,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,000,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,000,000.00	-
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>692,735,010.00</b>	<b>482,926,382.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	399,012,700.00	405,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	399,012,700.00	405,500.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	269,479,740.00	1,052,702.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	141,126,840.00	1,052,702.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	128,352,900.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	17,285,800.00	16,850,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,285,800.00	16,850,000.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	6,956,770.00	464,618,180.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6,956,770.00	464,618,180.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>800,789,749.07</b>	<b>682,147,825.30</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>800,789,749.07</b>	<b>682,147,825.30</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	751,189,749.07	679,545,607.30
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	294,486,318.33	355,471,091.30
210101	Үндсэн цалин	170,292,275.57	294,836,105.30
210102	Нэмэгдэл	67,102,791.00	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,322,633.34	-
210104	Урамшуулал	52,768,618.42	60,634,986.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	48,589,899.89	44,777,774.15
210201	Тэтгэврийн даатгал	36,565,886.80	32,406,159.19
210202	Тэтгэмжийн даатгал	3,012,487.22	3,096,220.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,409,987.38	2,476,978.45
210204	Ажилгүйдлийн даатгал	600,112.41	605,971.24

/Төгрөгөөр/

210205	Эрүүл мэндийн даатгал	6,001,426.08	6,192,444.37
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,280,011.00	12,247,782.00
210301	Гэрэл, цахилгаан	2,009,671.00	1,289,942.00
210302	Түлш, халаалт	12,270,340.00	10,707,840.00
210303	Цэвэр, бохир ус	-	250,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	35,236,649.51	26,772,044.99
210401	Бичиг хэрэг	2,822,790.00	1,878,600.00
210402	Тээвэр, шатахуун	15,776,960.00	19,076,644.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,486,800.00	1,770,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,700,600.00	4,046,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,830,199.51	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,619,300.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	312,824,622.41	178,404,608.25
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	289,887,961.11	153,284,275.44
210502	Хоол, хүнс	21,730,161.30	19,581,832.81
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,206,500.00	5,538,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,150,000.00	12,327,862.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	5,903,862.00
210604	Урсгал засвар	7,150,000.00	6,424,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,914,180.00	1,737,000.00
210702	Дотоод албан томилолт	2,914,180.00	1,737,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,938,500.00	221,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,000.00	35,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,500.00	26,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	39,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	33,769,567.93	47,585,644.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,063,100.00	11,804,489.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	817,485.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,888,982.93	35,781,155.61
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	49,600,000.00	2,602,218.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	49,600,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	48,600,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	2,602,218.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,602,218.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>20,554,260.93</b>	<b>(199,221,443.30)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>20,554,260.93</b>	<b>(199,221,443.30)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>692,735,010.00</b>	<b>609,605,382.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>692,735,010.00</b>	<b>609,605,382.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	399,012,700.00	127,014,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	399,012,700.00	127,014,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	269,479,740.00	1,052,702.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	141,126,840.00	1,052,702.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	128,352,900.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>17,285,800.00</b>	<b>16,850,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,285,800.00	16,850,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>6,956,770.00</b>	<b>464,688,180.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6,956,770.00	464,688,180.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>669,466,236.91</b>	<b>589,654,327.76</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>669,466,236.91</b>	<b>589,654,327.76</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>619,866,236.91</b>	<b>587,052,109.76</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>306,494,987.71</b>	<b>355,075,691.60</b>
210101	Үндсэн цалин	175,529,016.29	192,997,848.73
210102	Нэмэгдэл	68,827,488.00	93,215,869.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,158,000.00	3,511,065.03
210104	Урамшуулал	57,980,483.42	65,350,908.84
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36,974,118.20</b>	<b>44,780,286.16</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,120,074.27	32,394,593.82
210202	Тэтгэмжийн даатгал	2,805,239.91	3,096,421.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,237,471.83	2,477,139.46
210204	Ажилгүйдлийн даатгал	528,302.67	619,285.61
210205	Эрүүл мэндийн даатгал	5,283,029.52	6,192,845.37
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,792,511.00</b>	<b>12,247,782.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,009,671.00	1,289,942.00
210302	Түлш, халаалт	10,707,840.00	10,707,840.00
210303	Цэвэр, бохир ус	1,075,000.00	250,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,920,760.00</b>	<b>23,017,200.00</b>
210401	Бичиг хэрэг	3,733,550.00	1,776,100.00
210402	Тээвэр, шатахуун	17,009,360.00	15,632,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,486,800.00	1,770,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,191,050.00	3,463,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	375,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>166,305,930.00</b>	<b>131,805,200.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	139,095,500.00	109,815,800.00
210502	Хоол, хүнс	23,640,430.00	16,829,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,570,000.00	5,160,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>49,276,350.00</b>	<b>14,746,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,856,350.00	6,496,900.00
210604	Урсгал засвар	20,420,000.00	8,250,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,914,180.00</b>	<b>1,737,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,914,180.00	1,737,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,938,500.00</b>	<b>281,800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,000.00	95,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,500.00	26,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	39,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,248,900.00</b>	<b>3,360,250.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,248,900.00	3,360,250.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>49,600,000.00</b>	<b>2,602,218.00</b>

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	49,600,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	48,600,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	2,602,218.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,602,218.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>23,268,773.09</b>	<b>19,951,054.24</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>84,000.00</b>	<b>1,916,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>84,000.00</b>	<b>1,916,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	84,000.00	1,916,900.00
222001	Тоног төхөөрөмж	84,000.00	1,916,900.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(84,000.00)</b>	<b>(1,916,900.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	23,184,773.09	18,034,154.24
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		22,925,484.09
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	22,925,484.09	40,959,638.33

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	101,341,290.05	66,059,913.04	20,258,519.59		187,659,722.68
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	101,341,290.05	66,059,913.04	20,258,519.59	-	187,659,722.68
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	247,630,119.51		247,630,119.51
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	101,341,290.05	66,059,913.04	267,888,639.10	-	435,289,842.19
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	101,341,290.05	66,059,913.04	267,888,639.10	-	435,289,842.19
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	101,341,290.05	66,059,913.04	267,888,639.10	-	435,289,842.19
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(106,606,048.26)		(106,606,048.26)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	101,341,290.05	66,059,913.04	161,282,590.84	-	328,683,793.93

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	598,822,400.00	588,969,009.76

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	598,822,400.00	587,052,109.76
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	598,822,400.00	587,052,109.76
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	376,937,000.00	355,075,691.60
210101	Үндсэн цалин	214,534,900.00	192,997,848.73
210102	Нэмэгдэл	89,950,100.00	93,215,869.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,796,000.00	3,511,065.03
210104	Урамшуулал	66,656,000.00	65,350,908.84
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	47,117,100.00	44,780,286.16
210201	Тэтгэврийн даатгал	33,679,600.00	32,394,593.82
210202	Тэтгэмжийн даатгал	3,359,400.00	3,096,421.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,687,500.00	2,477,139.46
210204	Ажилгүйдлийн даатгал	671,900.00	619,285.61
210205	Эрүүл мэндийн даатгал	6,718,700.00	6,192,845.37
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,850,000.00	12,247,782.00
210301	Гэрэл, цахилгаан	2,000,000.00	1,289,942.00
210302	Түлш, халаалт	12,600,000.00	10,707,840.00
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	250,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,206,900.00	23,017,200.00
210401	Бичиг хэрэг	1,760,400.00	1,776,100.00
210402	Тээвэр, шатахуун	14,337,300.00	15,632,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,486,800.00	1,770,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,122,400.00	3,463,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	375,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	126,516,000.00	131,805,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	109,815,800.00	109,815,800.00
210502	Хоол, хүнс	15,510,200.00	16,829,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,190,000.00	5,160,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,116,800.00	14,746,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,666,800.00	6,496,900.00
210604	Урсгал засвар	2,450,000.00	8,250,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,899,600.00	1,737,000.00
210702	Дотоод албан томилолт	1,899,600.00	1,737,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,063,200.00	281,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00	95,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	294,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,400.00	26,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	39,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	-
210807	Газрын төлбөр	40,800.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	20,400.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,115,800.00	3,360,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,115,800.00	3,360,250.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>1,916,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	1,916,900.00
222001	Тоног төхөөрөмж	-	1,916,900.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	608,552,680.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	127,014,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	127,014,500.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	16,850,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	16,850,000.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	464,688,180.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	464,688,180.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>17,573,494.09</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>40,959,638.33</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	17.00	17.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	5.00	5.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00

## **2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Нэмэлт төсвийн гүйцэтгэл байхгүй.

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Орхон сумын Эрүүл мэндийн төв нь эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ба тайлант онд хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон эмнэлгийн анхан шатны тусламжийг жигд хүртээмжтэй чанартай үзүүлж салбартаа тэргүүлэх сумын эмнэлэг болоход оршино гэж тодорхойлжээ.

Дээрх зорилгыг биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлжээ. Үүнд:

- Жирэмсэн, нярай, төрсний дараах үеийн тусламж, үйлчилгээний чанарын баталгааг сайжруулах
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх
- Эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийг сайжруулах
- Орон нутагт зонхилон тохиолдох өвчлөлийг судалж шалтгааныг тогтоож, эмчилж сувилах
- Эмч ажилчдын ажиллах орчин, нөхцөл бололцоог сайжруулах
- Хүн амд эрүүл мэндийн боловсролыг олгох, сургалтын чанар сайжруулах

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.**

Орхон сумын Эрүүл мэндийн төв нь Төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, ХХОАТТХ, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль гэх мэт хууль эрх зүйн орчны хүрээнд үй ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Боловсон хүчний нөөц дутмагаас тайлант онд дотоод хяналтын ажилтан байгаагүй, дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулсан ч тавих хяналт сул байгаагаас тайлант онд үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийгдээгүй байна.

Дотоод аудит/ аудиторын чиг үүрэг бүхий орон тооны ажилтан байхгүй тул дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

Тус байгууллагад Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас 2022 онд санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 5 төлбөрийн акт, 2 албан шаардлага, эмийн тайлан зарцуулалттай холбоотой асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг аймгийн Засаг даргын А/424 тоот захирамжаар 2020 онд батлуулж Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг тусгасан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарт, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган аймаг Орхон сумын Эрүүл мэндийн төвийн 2022 санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 88,881.4 мянган төгрөгөөр буюу 0.17 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	22,925.5	40,959.6	18,034.1
Авлага	127,410.6	0	(127,410.6)
Бараа материал	100,843.5	104,580.8	3,737.3
Үндсэн хөрөнгө	274,904.8	309,696.7	34,791.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>503,158.9</b>	<b>414,277.5</b>	<b>88,881.40</b>
Өр төлбөр	92.3	70.0	22.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	0		0
Дахин үнэлгээний зөрүү	0	0	0
Хуримтлагдсан үр дүн	(267,888.6)	(161,282.6)	(106,606.0)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>431,072.2</b>	<b>324,443.8</b>	<b>(106,628.4)</b>

Мөнгөн хөрөнгийн данс 40,959.6 мянган төгрөг болж 18,034.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайланд онд орон тоо дутуу ажиллаж цалингийн зардал хэмнэсэнтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 0.0 мянган төгрөг болж 127,410.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас ковид-19 өвчнөөр хэвтэн болон гэрээр эмчлүүлсэн иргэд, ковид-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдсан иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламжийн авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материалын данс 104,580.8 мянган төгрөг болж 3,737.3 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материал 13,320.3 төгрөгөөр, бусад хангамжийн материал 514.1 төгрөгөөр өсөж, хүнсний материал 2,752.5 төгрөгөөр, тусгай зориулалтын материал 9,824.3 төгрөгөөр, аж ахуйн материал 1,315.4 мянган төгрөгөөр, бичиг хэргийн материал 387.2 мянган төгрөгөөр, түлш шатах тослох материал 3,444.6 мянган төгрөгөөр тус тус буурсан нь төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн ажилласантай холбоотой. Тайлангийн хугацаанд 2,257.3 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 3,498.2 мянган төгрөгийн аж ахуйн материал, 15,632.1 мянган төгрөгийн шатах тослох материал, 5,175.5 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл,

110,132.1 мянган төгрөгийн эм, 1,248.5 мянган төгрөгийн барилгын материал, 2,576.3 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, 17,079.4 мянган төгрөгийн хүнсний материал, бусад хангамжийн материал 15,198.7 нийт 172,798.1 мянган төгрөгийн бараа материал худалдан, ЭМГ-аас 58,165.1 мянган төгрөгийн эм, боох материал, аж ахуйн материал шилжүүлэн тус тус авч 2,644.54 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 4,813.6 мянган төгрөгийн аж ахуйн материал, 19,076.6 мянган төгрөгийн шатах тослох материал, 153,284.3 мянган төгрөгийн эм, 5,175.5 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 1,248.5 мянган төгрөгийн барилгын материал, 9,400.7 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, 19,831.8 мянган төгрөгийн хүнсний материал, 220.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал нийт 215,695.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна. Мөн 11,750.3 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 309,696.7 мянган төгрөг болж 34,791.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлангийн хугацаанд эрүүл мэндийн яамнаас тоног төхөөрөмж нийт 32,875 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, 1,916.9 мянган төгрөгийн хөлдөөгч, принтер түүний дагалдах хэрэгслийг төсвийн хөрөнгөөр худалдан авсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 598,822.4 мянган төгрөгөөр орон нутгийн төсвөөс 18,950.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 18,950.0 зардлыг мянган төгрөгөөр бууруулж, 598,822.4 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь шинээр баригдаж байгаа эмнэлэг ашиглалтад орохтой холбоотойгоор халаалтын зардлыг илүү төлөвлөсөн нь шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 581,972.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 16,850.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 609,428.6 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 16,850.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 591,571.1 мянган төгрөг буюу 94 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 34,707.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулж орон нутгийн төсөвт 2,602.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Үндсэн үйл ажиллагаа</b>	<b>626,278.6</b>	<b>591,571.1</b>	<b>34,707.5</b>	<b>94%</b>
Нэг иргэнд ногдох нормативаар үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	279,840.5	248,090.9	31,749.5	89%
Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	154,953.0	151,998.3	2,954.7	98%
Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	174,635.1	174,631.9	3.1	99%
Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	16,850.0	16,850.0	0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Тайлант онд нэмэлт төсөв байхгүй болно.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн Орхон сумын ЭМТ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах дансны ангилал, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн, аудитор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр бусд буюу тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсөв 1,326.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 19,896.7 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын ахлах нягтлан бодогч төрийн хэмнэлтийн хуулиар бүх ажилчдад сургалтыг зохион байгуулж хэмнэгдэж болох зардал болон тэвчих зардлууд дээр санал бодлоо солилцон ажилласан. Ажилчид бичгийн хэрэгслийн зардлыг хэмнэх, гэрэл цахилгааныг бүрэн унтрааж явах, усны алдагдал гаргахгүй байхын тулд слесарь тухай бүр нь үзлэг хийн тэмдэглэл хөтлөх зэрэг арга хэмжээнүүд авч ажилласан.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын дансны аж ахуй материалын дансны ангилалтай холбоотой 2 зөвлөмж 5 албан шаардлага хүргүүлсэн бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0			
Албан шаардлага	5	123,334.9	5	123,334.9	100
Зөвлөмж	2	7,506.2	2	7,506.2	100
Нийт дүн	7	0	7	130,841.1	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон сумын Эрүүл мэндийн төвийн эмийн зарцуулалтыг нягтлан шалгах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 647,936.8 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 9,630,927.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 284,992.2 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 353,313.7 мянган төгрөгийн эмийн тайлангийн орлого, зарцуулалт, тайлагналтай холбоотой зөрчилтэй асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

### 5.1 Төлбөрийн акт

- Шатахууны зардлаас түүвэрлэн тулгалт хийхэд шатахуун тооцож олгохдоо автомашины зарцуулах шатахууны норм нормативыг баримтлаагүй нийт 576.1 мянган төгрөгийг илүү тооцон олгож Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 190 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Хүнсний зардлаас түүвэрлэн тулгалт хийхэд хүнсний тайланд нормоор тогоочид олгосон хүнснээс 1,649.4 мянган төгрөгөөр илүү дүнгээр зарлагдсан нь НББ-ийн тухай хуулийн 13.1, 13.1.7, 20.2.4 дэхь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна;
- Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн тушаалаар баталсан үр дүнгийн урамшуулал олгох хувийг урамшуулал олгохдоо нийт 1,937.9 мянган төгрөгийг илүү тооцон олгосон нь НББ-ийн тухай хуулийн 13.1,14.1.1, 20.1.1, 20.1.2, 20.2.4 дахь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна;
- Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн тушаалыг зөрчин ковидын урамшууллын мөнгөн дүнг өөрчлөн албан хаагчдад 4,462.5 мянган төгрөгөөр илүү, дутуу тооцоолон олгосон нь НББ-ийн тухай хуулийн 13.1,14.1.1, 20.1.1, 20.1.2, 20.2.4 дахь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна;
- Бодогдсон цалингаас суутгах НДШ, ХХОАТ-ын суутгалыг дутуу суутган гарт олгох цалинг 1004.8 мянган төгрөгөөр илүү олгосон нь НББ-ийн тухай хуулийн 13.1,14.1.1, 20.1.1, 20.1.2, 20.2.4 дахь заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй зэрэг зөрчлүүдэд төлбөрийн акт хүргүүллээ.

### 5.2 Албан шаардлага

- Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шатахууны зардлаас түүвэрлэн тулгалт хийхэд шатахуун тооцож олгохдоо автомашины зарцуулах шатахууны норм нормативыг баримтлаагүй	1	576.1	1	576.1								
Хүнсний зардлаас түүвэрлэн тулгалт хийхэд хүнсний тайланд нормоор тогоочид олгосон хүнснээс илүү дүнгээр зарлагдсан	1	1,649.4	1	1,649.4								
Санхүүгийн тайлангийн тодруулга дахь эмийн үлдэгдэл эмийн тайлангийн эхний үлдэгдлээс 1,439.4, эцсийн үлдэгдлээс 36,654.4 мянган төгрөгөөр зөрүүтэй, Санхүүгийн тайлангийн тодруулга дахь тайлант онд нэмэгдсэн эм, эмийн тайлангийн тайлант онд нэмэгдсэн эмээс 112,626,9 мянган төгрөгөөр зөрүүтэй, Санхүүгийн тайлангийн тодруулга дахь тайлант онд зарцуулсан эм, эмийн тайлангийн	1	353,313.7									1	353,313.7

